

**ХАЛДВАР ӨВЧНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ШАРАВНЯМБУУГИЙН  
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

**НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин 1-р хагас жил	Биелэлт	Үнэлгээ
<b>1</b>	<p><b>Арга хэмжээ № 1.1.</b> Халдварт өвчнийг эрт сэргэмжлүүлэх хариу арга хэмжээний тандалтын тогтолцоог орон нутагт хэрэгжүүлэх, цочмог халдварт өвчний дэгдэлтийн үед удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах</p>	<p>Тандалтаар бүртгэгдсэн хам шинж, сэжигтэй тохиолдлын тоо, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэж болзошгүй дэгдэлтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал.</p>	<p>Цочмог халдварт өвчний тохиолдлуудыг тандалтын тогтолцоогоор бүртгэгдсэн хувь 90</p>	<p>Халдварт өвчний хам шинж сэжигтэй тохиолдлын /EWAR/ мэдээг ЭМБ-уудаас 7 хоног бүр авч нэгтгэн ажиглаа. 2025 оны 06 сарын байдлаар Цочмог халдварт өвчний 256 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд аймгийн дунджаар 10000 хүн амд 27.3 тохиолдол байна. Цочмог халдварт өвчний өвчлөлийн түвшин Эрдэнэмандал, Жаргалант, Хотонт, Эрдэнэбулган суманд хамгийн их буюу 10000 хүн амд 31-79.9 тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>Харин Их тамир, Чулуут, Хангай, Тариат, Өндөр-Улаан, Цэцэрлэг, Хайрхан, Батцэнгэл, Өлзийт, Өгийнур, Хашаат, Цэнхэр, Төвшрүүлэх, Булган, Цахир, Хоршоолол сумуудын 10000 хүн дахь цочмог халдварт өвчний өвчлөл аймгийн дунджаас бага буюу 2-19.7 тохиолдол бүртгэгдсэн байна.</p> <p>Хагас жилийн байдлаар Цочмог халдварт өвчнөөс менингит-1, Улаанбурхан Эмнэлзүй болон лаборатори-41, салхинцэцэг-166 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд халдвар голомтлон гарсан сумдад 72 цагийн дотор дархлаажуулсан. халдвар эсэргүүцэх арга хэмжээний заавар зөвлөгөөг тухай бүр өгч ажигласан.</p>	
<p><b>Зорилт 1. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:</b></p>					

	<p><b>2</b></p>	<p><b>Арга хэмжээ № 1.2.</b> Дархлаажуулалттай халдварт өвчний тандалтыг эрүүл мэндийн байгууллагуудад сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>Тандалтыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан</p>	<p>Тандалтын мэдээ авч нэгтгэх 25 удаа, Дархлаажуулалтын хамралтын байдлыг үнэлэн эргэн мэдээлэл, зөвлөмж 2 удаа хүргүүлсэн байна.</p> <p>Сэжигтэй Тохиолдлоос тухай бүр сорьц авч, оношийг баталгаажуулсан байна</p>	<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар халдварт өвчний /EWAR/ тандалтын мэдээг ЭМБ-уудаас 49 удаа авч халдварт өвчний хам шинж, сэжигтэй 256 тохиолдлыг бүртгэсэн бөгөөд тарилгатай халдвар /халууралт, тууралттай/ - ийн батлагдсан тохиолдол-61 ХӨСҮТ-ийн улаанбурханы лавлагаа лабораторид хүргэн шинжилгээнд хамруулахад Улаанбурхан, Улаанууд өвчний өвөрмөц IgM- 40 эерэг, эмнэлзүйгээр-21 тохиолдол тодорхойлогдсон.</p> <p>ЭМГ-аас 2025.06.23-нд №04/664 тоот, албан бичгээр боловсруулан анхан шатны ЭМБ-уудад “Улаанбурхан, улаануудын дархлаажуулалт, хүндрэлийн үеийн эмнэлзүйн менежмент”-ийн талаар цахимаар сургалтыг 4 удаа зохион байгууллаа.</p> <p>Тус сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, вакцинатор, багийн эмч, сувиллагч нарыг хамруулан 19 сум, 3 ӨЭМТ-ийн нийт давхардсан тоогоор 180 эмч, мэргэжилтэн вакцинатор хамрагдаж мэдлэгээ дээшлүүллээ.</p> <p>Мөн Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тухай ЭМГ-ын даргын 2025.02.26-ний өдрийн 03 дугаар тоот, албан даалгаврыг Анхан шатны ЭМБ-ууд, НЭ, Хувийн хэвшлийн ЭМБ-уудад хүргүүлж тайланг авч нэгтгэсэн.</p> <p>ЭМГ-ын даргын 2025.03.17-ний өдрийн №04/164 тоот, албан бичгээр зөвлөмжийг Болговсролын газар болон эрүүл мэндийн байгууллагуудад “Улаанбурхан, улаануудын дэгдэлтээс сэргийлэх</p>
--	-----------------	---	---	---	---

			<p>сургууль, цэцэрлэгийн орчинд халдварын тархалтыг бууруулах” мэдээлэл зөвлөмжийг давхардсан тоогоор 4 удаа хүргүүлсэн.</p> <p>Архангай аймгийн хэмжээнд улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтын нэгдсэн бичил төлөвлөгөө (дархлаажуулалтын цэгээр) тус бүртгэн гаргаж ХӨСҮТ-рүү явуулсан.</p> <p>ЭМГ-ын даргын 2025.03.14-ний №04/158 тоот, албан бичгээр Анхан шатны ЭМБ-уудад УГТУ вакцинд хамрагдаагүй, вакцины 2 тунд бүрэн хамрагдаагүй хүүхдүүдийн судалгааг нарийвчилсан гаргаж нөхөн дархлаажуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2015 оноос хойш улаанбурханы дархлаажуулалтад <b>n=3948 (100%)</b> хүүхэд хамрагдахаас бүрэн тунгаа авсан <b>n=2812 (71%)</b>- тай, вакцингүй <b>n=78 (2%)</b>, Үүнээс нас барсан <b>n=41 (1%)</b>, Улаанбаатар хот руу шилжсэн <b>n=477</b>, өөр аймаг руу шилжсэн <b>n=2168</b>, УГУ-ын нөхөн дархлаажуулалт 6 сарын 24 –ний байдлаар 784, Улаанбурхан, улаануудыг 367 хүмүүсийг нөхөн дархлаажуулсан байна.</p> <p>Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлад шилжсэнтэй холбоотой <b>“Хаалга бүхэнд хүрч хүүхэд бүрийг хамгаалъя”</b>-аяны хүрээнд Улаанбурхан өвчнөөс сэргийлэх халдварын тархалтыг зогсоох зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад нөхөн дархлаажуулах байнгын болон явуулын цэгийг ажиллуулж байна. Мөн 0-15 насны дархлаажуулалтанд хамрагдвал зохих хүүхдийн судалгааг эрүүл мэндийн байгууллага тус бүрээр гарган товлолын дархлаажуулалтаас</p>	
--	--	--	--	--

		<p>хоцорсон болон бүрэн тун аваагүй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гарган дархлаажуулалтанд хамрагдалтыг эрчимжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд нөхөн дархлаажуулалтанд хамрагдвал зохих 0-15 насны 22357 хүүхэд байгаагаас дархлаажуулалтанд хамрагдсан 19770 хүүхэд буюу 88.4 хувьтай байна. 402 хүүхэд буюу дархлаажуулалтанд хамрагдвал зохих хүүхдүүдийн 1.8% нь улаанбурхны вакцинд хамрагдаагүй байгааг нөхөн дархлаажуулалтанд хамруулахаар ажиллаж байна. 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 0-15 насны 402 хүүхдийг нөхөн дархлаажуулалтанд хамруулаад байна.</p> <p>Архангай аймгийн хэмжээнд нэмэлтээр 6-8 сартай хүүхдийг дархлаажуулалтад хамрагдвал зохих 280 хүүхэд байгаагаас дархлаажуулалтад хамрагдсан 160 буюу 57.1 хувьтай байна. Үлдсэн 118 буюу 42.1 хувийг дархлаажуулаагүй байна.</p> <p>Тус аяны хүрээнд Архангай аймгийн сүм өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дархлаажуулалтын 22 байнгын цэг, явууллын 4 цэгийг ажиллуулан нөхөн дархлаажуулалтыг хийж эхэллээ.</p> <p>Өдөрлөг арга хэмжээ улс орон даяар нэгэн зэрэг буюу 2025 оны 07 сарын 01-ны 11:40-13:40 минутын хооронд эхэлсэн ба Архангай аймгийн "19 сумын ЭМБ-ууд, 3 ӨЭМТ"-үүд орон нутгийн иргэдэд уг өвчнөөс сэргийлэх мэдээлэл зөвлөгөө өгч, зорилготой насны хүүхдүүдийг дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулаа.</p>
--	--	---

				Архангай аймгийн ЗДТГ-тай хамтран нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус албан байгууллагуудад зөвлөмж улаанбурханы чиглэлээр нөхөн дархлаажуулах хүүхдийн тоог нарийвчлан гаргах, чиглэлээр албан бичиг хүргүүлсэн.	
3	Арга хэмжээ № 1.3. Дархлаажуулалтын нэгжүүдээс сар бүр ирүүлсэн дархлаажуулалтын хамралт, зарцуулалтын мэдээг хянах, ХӨСҮТ-д мэлээлэх	Сарын мэдээ хянаж эргэн мэдээлэл, зөвлөмж хүргэсэн тоо	2	Товлол, тархвар судлал, сайн дурын дархлаажуулалтын сарын мэдээг Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдээс сар бүрийн 1-нд авч дархлаажуулалтын хамралт, вакцин био бэлдмэл, дагалдах хэрэгслийн зарцуулалтыг Архангай аймгийн хэмжээнд мэдээг гарган ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын алба, ЭМГ-ын дүн бүртгэлд сар бүр хүргүүлэн ажиглаа. 2025 оны 6 дугаар сарын байдлаар дархлаажуулалтын нэгжүүдийн хамралтын мэдээг хянан эргэн мэдээлэл, зөвлөмжийг 1 удаа хүргүүлэн аймгийн хэмжээнд 0-15 насны хүүхдийн товлолын дархлаажуулалтын хамралт 91.8%-тай буюу өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар буурсан байна.	
4	Арга хэмжээ № 1.4. Дархлаажуулалтын дараах хүнд урвал, хүндрэл бүртгэгдсэн тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулсан хувь	0	2025 оны 06 сарын байдлаар байдлаар давхардсан тоогоор 0-15 насны 5218 хүүхдийг тарилгатай халдварт өвчинөөр дархлаажуулсан, ДДУХ-ийн тандалтад хамруулсан. Тандалтаар ДДУХ-ийн ноцтой тохиолдол болон тарилгатай халдварт өвчний тохиолдол гараагүй. Харин Улаанбурхан өвчний зөөвөрлөгдсөн нийт 42 тохиолдол бүртгэгдэж лабораторийн шинжилгээгээр болон эмнэлзүйгээр батлагдсан. Үүнээс Эрдэнэбулган-5, Өлзийт-4, Булган-2, Төвшрүүлэх-5, Хотонт-25, Цэнхэр-1 тохиолдол батлагдсан.	

	<p><b>Арга хэмжээ № 1.5.</b> Аймгийн хэмжээнд 2026 нд хэрэглэх хэрэглэх биобэлдмэл, хэрэгслийн тооцоог гарган захиалгыг ХӨСҮТ-д хүргүүлэх</p>	<p>ХӨСҮТ-д хүргүүлсэн вакцин, биобэлдмэлийн захиалга.</p>	<p>2025 онд товллын болон тархвар судлалын заалтаар хэрэглэх вакцин биобэлдмэлийн захиалгыг хийсэн байна.</p>	<p>2026 онд аймгийн хэмжээнд шаардлагатай товлол, тархвар судлалын заалтаар хийн вакцин биобэлдмэлийн тооцоог хийн ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын алба, ЗӨСҮТ-д тус тус цахимгаар хүргүүлсэн.</p>	
<p><b>6</b></p>	<p><b>Арга хэмжээ № 1.6.</b> аймгийн хэмжээнд хэрэглэх товлол, тархвар судлал, сайн дурын дархлаажуулалтанд шаардлагатай вакцин, биобэлдмэл, хэрэгслийн тасалдалгүй байдлыг хангах.</p>	<p>Татан авалт хийсэн тоо, вакцин биобэлдмэлийн тасалдал үүсээгүй байна.</p>	<p>2 удаагийн татан авалт</p>	<p>Хагас жилийн байдлаар ХӨСҮТ-өөс товлол, тархвар судлал, сайн дурын дархлаажуулалтад хэрэглэх вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн 8 удаагийн тантан авалт хийсэн. Аймгийн хэмжээнд вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн тасалдалгүй дархлаажуулалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.</p>	
<p><b>7</b></p>	<p><b>Арга хэмжээ № 1.7.</b> Дархлаажуулалтын хоногийг аймгийн хэмжээнд</p>	<p>Тэмдэглэх удирдамж гаргаж,</p>	<p>Нөхөн дархлаажуулалтын арга хэмжээг 1 удаа</p>	<p>Дэлхийн дархлаажуулалтын долоо хоногийн хүрээнд дархлаажуулалтын долоо хоногийг “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрт хүртээе” уриан дор 2025 оны 04 дүгээр сарын 24-нөөс 30-</p>	

	зохион байгуулах	хэрэгжүүлсэн тайлан	зохион байгуулсан байна.
			<p>ны хооронд зохион байгууллаа.</p> <p>Тус аяны хурээнд Архангай аймгийн Эрүүл мэндийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн №04/281 дугаар "Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрт хүртээе" аяны удирдамж боловсруулан батлуулж 19 Сум, өрхийн Эрүүл мэндийн байгууллагад хургуулсан.</p> <p><b>Тус аяны хүрээнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Архангай аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Ар-Мөнжин, Ар-Манал, Ар-Мөнгөнчигнуур ӨЭМТ-тэй хамтран дархлаажуулалтын цэгүүд, дархлаажуулалтын баг томилон ажиглуулж, ард иргэдэд дархлаажуулалтын үйл ажиллагааг таниулах, сургуульд суурилсан дархлаажуулалтын цэгийг байгуулж, сургалтад нийт 120 гаруй багш, эцэг, эх асран хамгаалагч нар оролцож, товлотт насны 250 гаруй хүүхдийг дархлаажуулалтад хамрууллаа.</li> <li>2. Улаанбурхан, ХГВ-ийн дархлаажуулалтын талаар урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн сүлжээнд 20 төрлийн зөвлөмж, 5 видео, инфографикийг цахим хэлбэрээр түгээн мэдээлэл сурталчилгааны ажлыг эрчимжүүлсэн.</li> <li>3. Иргэдэд Улаанбурхан, гахайн хавдар, улаанууд, ХГВ-ийн эсрэг дархлаажуулалтын 6 төрлийн 350 гаруй гарын авлага, зөвлөмж тараасан.</li> <li>4. Улаанбурхан, ХГВ-ийн дархлаажуулалтын</li> </ol>

				<p>талаар орон нутгийн телевизүүдээр болон Эрүүл мэндийн газрын цахим хуудсаар дамжуулан 19 сүманд мэдээ мэдээлэл хүргэж өөрсдийн пейж хуудсаар дамжуулан нийтэлсэн.</p> <p>5. Эцэг, эх асран хамгаалагч нарт “Хүний папиллома вирусийн шалтгаант өвчин эмгэг вакцинаар сэргийлдэг халдварт өвчний хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх вакцины ач холбогдол”-ийн талаар нийт 500 гаруй иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгов.</p> <p>6. Дархлаажуулалтын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах, дархлаажуулах ажлыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг хариуцлагыг сайжруулах чиглэлээр орон нутгийн түвшинд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хамруулан сүм, орон нутгийн түвшинд зохион байгуулсан.</p>	
8	<p><b>Арга хэмжээ № 1.8.</b> Халдварт өвчний хам шинж сэжигтэй тохиолдлын /EWAR/ мэдээг хянаж, халдварт өвчнийг эрт сээрэмжлүүлэх хариу арга</p>	<p>Халдварт өвчнийг эрт сээрэмжлүүлэх хариу арга хэмжээг алдалгүй авч</p>	100%	<p>Халдварт өвчний хам шинж сэжигтэй тохиолдлын /EWAR/ мэдээг ЭМБ-удаас 7 хоног бүр авч нэгтгэн ажиглаа. 2025 оны 06 сарын байдлаар аймгийн хэмжээнд халдварт өвчний хам шинж, сэжигтэй 299 тохиолдлыг бүртгэн цочмог халдвар 215, архаг халдвар 84 тохиолдлын оношийг</p>	

хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх	хэрэгжүүлсэн хувь		<p>Баталгаажуулан ЭМХТ-д мэдээлсэн. Үүнд: Менингит-1, салхинцэцэг-156, цусан суулга-17, энтеровируст халдвар-1, сүрьеэ-20, Улаанбурхан-41, гар хөл амны өвчин-6, халдварт эритем-1, хачигт рикеттиоз-6, тэмбүү-26, заг хүйтэн-21, трихомониаз-17, хам шинж оношилгоо-53 улаан эсэргэнэ-2, гахайн хавдар-2, ёлом-3, салымонелёз-2, тус тус бүртгэгдээд байна.</p> <p>Цочмог болон архаг халдварт өвчний тандалт судалгаа хийн хавьтлыг тогтоох, үзлэг шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулан ажиглав. Улаанбурхан болон салхинцэцгийн халдвар голомтлон гарсан сумдад халдвар эсэргүүцэх арга хэмжээний заавар зөвлөгөөг тухай бүр өгч ажиглав.</p>
<p><b>9</b></p> <p><b>Арга хэмжээ № 1.9.</b> Сургууль, цэцэрлэгийн орчинд амьсгалын замын болон гэдэсний халдварт өвчин тархах эрсдэлээс сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон баримталж буй дэглэмд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх</p>	<p>Үнэлгээний тайлан, хургуулсан зөвлөмж, үнэлгээ хийсэн сургууль, цэцэрлэгийн тоо</p>	1	<p>2025 оны хагас жилийн байдлаар сургууль, цэцэрлэгийн орчинд Улаанбурхан, салхинцэцэгийн халдвар голомтлон гарсантай холбогдуулан улаанбурхан, салхинцэцэгийн халдвараас урьдчилан сэргийлэх болон халдварын тархалтыг бууруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан ЭМГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн №04/147 тоот албан бичгээр аймгийн Боловсролын газарт хүргүүлсэн.</p> <p>Мөн Эрдэнэбулган, Жаргалант, Эрдэнэмандал, сумын ЕБС-иуд салхинцэцэг өвчин голомтлон гарсан тул өвчнөөс сэргийлэх, халдварын тархалтыг таслан зогсоох, хүндрэл тархалтыг бууруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан ЭМГ-ын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн №04/148 тоот албан бичгээр сумын</p>

				Боловсролын газарт хүргүүлсэн.	
10	<b>Арга хэмжээ № 1.10.</b> Халдварт өвчний бүртгэл, мэдээллийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах	ХӨ-ний бүртгэл, мэдээллийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан	ХӨ-ний мэдээнд сар бүр үнэлгээ хийж, эргэн, мэдээлэл, зөвлөмжийг 2 удаа ЭМБ-уудад хүргүүлсэн байна.	Халдварт өвчний мэдээлэх хуудас НИФО праграммыг цахимд хөтлөхгүй байгаа Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч, сувилагч, дүн бүртгэгч нартай тухай бүр холбогдон бүртгэл мэдээллийг сайжруулж, цахимд нөхөн шивэх арга хэмжээ авч ажилласан.	
11	<b>Арга хэмжээ № 1.11.</b> Халдварт мэдээнүүдийг ЭМБ-аас хугацаанд нь бүрэн авч нэгтгэн, холбогдох байгууллагуудад мэдээлэх	ЭМБ-аас мэдээг хугацаанд нь авсан хувь, мэдээг бүрэн зөв нэгтгэж, холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн хувь	100%	Хагас жилийн байдлаар Архангай аймгийн хэмжээнд бүртгэгдсэн цочмог халдварт өвчин, Сүрьеэ, БЗДХ-уудын сарын мэдээ тайланг ЭМБ-уудаас авч нэгтгэн ажилласан. Цочмог халдварт өвчний-215, архаг халдварт өвчин-84 тохиолдол, сүрьеэ болон БЗДХ-ийн 84 тохиолдлыг тус бүртгэн ЭМХ-ийн төвд мэдээлсэн. Мэдээлэгдсэн нийт халдварт өвчнүүдийн АМ-2, АМ-3, АМ-4 маягтын дагуу Н-Info 3 цахим програмын бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд тогтомог хяналт хийн ажиллаж байна.	
<b>Зорилт 2. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, өвчлөлийг эрт илрүүлж, хяналт, эмчилгээнд хамруулж, хүндрэл, тархалтаас сэргийлэх</b>					
12	<b>Арга хэмжээ № 2.1.</b> Суманд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах	Үзлэг хийсэн сумын тоо Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн тоо	Үзлэг хийсэн сумын тоо – 5 Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн тоо – 1000	2025 оны хагас жилийн байдлаар 5 суманд эрсдэлт бүлгийн 294 хүн үзэж 48 тохиолдол, бэлгийн замаар дамжих халдварын 473-н зорилтот бүлгийн иргэдийг хамруулахад шинээр илэрсэн өвчлөг: тэмбүүгийн халдвар-21, заг хүйтний халдвар-5, трихомоноиазын халдвар-47, бэлгийн хөрлөс халдвар-3, бэлгийн шархлагаат халдвар-2, мөөгөнцөрт халдвар-71, нянгийн гаралтай үтрээний үрэвсэл-107, элгний В гепатит вирус-21,	

				элэгний С гепатит вирус-18, нийт БЗДХ- зонхилон халдвар-78, бусад халдвар-178 тус тус илрүүлж хавьтлын тандалт судалгааг хийн хяналтад авч эмчилгээнд хамруулсан.			
13	<p><b>Арга хэмжээ № 2.2.</b> Сүрьеэгийн тохиолдлоос тээвэрлэх үйл идэвхжүүлэх ажиглагааг байгуулах</p>	<p>сэжигтэй сорьц авч үйл зохион</p>	<p>Идэвхжүүлэх чиглэлээр гаргасан албан бичиг</p>	<p>Гаргасан албан бичиг, тоот-2</p>	<p>Тээвэрлэсэн сорьцын тоо - 150</p>	<p>Сүрьеэгээр өвдсөн иргэдийн хавьтлуудыг үзлэг оношилгоонд 5 сумын 294 эрсдэлт бүлгийн иргэдийг сүрьеэгийн үзлэг, рентген оношилгоонд хамруулж, 21 сэжигтэй тохиолдлуудаас цэрний шинжилгээ авсан.</p>	
14	<p><b>Арга хэмжээ № 2.3</b> Бэлгийн замаар халдварт урьдчилан талаар, иргэдийн дээшлүүлэх сурталчилгааны ажиглагааг байгуулах</p>	<p>дамжих өвчнөөс сэргийлэх сургалт, үйл зохион</p>	<p>Сурталтын тоо-2</p>	<p>Сургалтын тоо - 2</p>	<p>Сурталчилгааны тоо - 2</p>	<p>Нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сурталтыг Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд тогтмол хийж мэдээлгээр хангаж байна. Ирээдүйн босго ӨҮЭМ-ийн төвөөс Эрдэнэбулган сумын 2-р сургууль, 5-р сургууль, Чулуут сумын ахлах ангийн сурагчдад “Өсвөр нас – Эрүүл мэнд”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Охидын эрүүл ахуй”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр 4 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад 260 гаруй охид хамрагдаж мэдлэгээ сайжруулсан. Архангай Политехникийн коллежийн 45 оюутанд “НҮЭМ”, “Гэр бүл төлөвлөлт”, “БЗДХ” сэдвээр сургалт хийж мэдлэгийн сайжруулсан. МУБИС-ийн харьяа Багшийн сургуулийн хүсэлтээр оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох 3 удаагийн сургалтад давхардсан тоогоор 250 оюутан хамрагдсан байна.</p>	

**Зорилт 3. Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх**

<p><b>15</b></p> <p>Арга хэмжээ № 3.1. Эрүүл мэндийн байгууллагуудад Халдварт хянах өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээ, дэмжлэгт хяналт хийж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж хүргүүлэх, гүйцэтгэлийн хяналт хийх</p>	<p>Дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо</p>	<p>Дэмжлэгт хийсэн ӨЭМТ – 3, хяналт СЭМТ-5,</p>	<p>ЭМГ-ын даргын 2025 оны 05 дугаар 05-ны А/53 дугаар тушаалын дагуу анхан шатны ЭМБ-уудад дэмжлэгт хяналт хийж тухай бүрт заавар зөвлөгөө өгсөн.</p>
<p><b>16</b></p> <p>Арга хэмжээ № 3.2 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хугацаатай албан бичиг, цаг үеийн ажил, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх</p>	<p>Сар, улирал, жилийн эцсийн тайлан, хугацаатай албан бичиг, цаг үеийн ажил, бусад тайлан мэдээллийг хугацаанд нь журмын дагуу тайлагнасан хувь</p>	<p>100%</p>	<p>ТАХ-ийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар 1 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан. Өөрийн хариуцсан халдварт өвчин, дархлаажуулалтын чиглэлээр шинээр гарсан бодлогын баримт бичгийг ЭМБ-уудад шуурхай хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар хугацаатай албан, мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь гарган ажилласан.</p>

**ХОЁР МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт
1	Арга хэмжээ № 1.	Сургалтанд	Магистрын	Ирэх намраас бүртгэл эхлэхээр суралцах

Магистрын зэрэг олгох сургалтанд суралцах	элсэн суралцсан байх	сургалтанд элсэн суралцаж эхэлсэн байна	төлөвлөгөөтэй байгаа.
2 <b>Арга хэмжээ № 2.</b> Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох байгууллагуудаас зохион байгуулсан сургалтуудад бүрэн оролцох	Мэдлэг, чадвар нэмэгдсэн байна	ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр бүрэн хамрагдах	Тухай бүр оролцсон.

Нийт арга хэмжээний тоо: 18

**ГУРАВ: НЭМЭЛТ АЖЛЫН ТАЙЛАН:**

№	Хэрэгжүүлсэн ажил	Үнэлгээ
17	<p>Орон нутгийн иргэдэд ТТӨ-ний өвчлөл, хүндрэлээс урьдчилан сэргийлэлтийг сайжруулах, орон нутгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа нэмэгдүүлж цахим сурталчилгааг олон нийтийн сүлжээгээр дамжуулан 2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2025 оны 1 дүгээр сарын 22-ны хооронд Архангай аймгийн иргэдийг олон нийтийн газраар явах болон үйлчилгээний байгууллагаар үйлчлүүлэхдээ амны хаалт хэрэглэх, гараа тогтмол угаах зэрэг дадлуудыг хэвшүүлэх, эрүүл мэндийн байгууллагын ажилчид иргэдэд зөвлөгөө, мэдээлэл хүргэх зорилгоор <b>“МАСКАА ЗҮҮЕ ГАРАА УГААЯ”</b> аяныг цахим сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Иймд Эрүүл мэндийн газраас 2024 оны 12 дугаар сарын 11 –ны өдрийн 04/1024 тоот, удирдамж боловсруулан анхан шатны ЭМБ-уудад хүргүүлсэн.</p> <p>Тус аяны хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Харьяа орон нутгийн ЕБС-ийн сурагчид, СӨБ-ийн байгууллагаар дамжуулан бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд, асран хамгаалагч нарт амны хаалт зүүхийн ач холбогдлын талаар сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгууллаа.</li> <li>2. ЭМГ болон Анхан шатны ЭМБ-ууд цахим хуудсаар дамжуулан 24 төрлийн зурагт хуудас сурталчилгааны материалыг түгээж иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлж, давхардсан тоогоор 485256 гаруй иргэн хандаж мэдээлэл авсан байна</li> <li>3. МАСКАА ЗҮҮЕ, ГАРАА УГААЯ” аянд сошиал чээлэнжид нэгдэж амьсгалын замын цочмог халдвар болон томму, томму төст өвчний идэвхжил дэгдэлтийг бууруулах үйл ажиллагаанд Эрүүл мэндийн байгууллага болон бусад албан</li> </ol>	

<p>байгууллагыг уриалсан.</p>	
<p><b>18</b> Иргэдийг осол гэмтэлд өртөхөөс сэргийлэх, осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор мэдээлэл сургалт сурталчилгаа нэмэгдүүлж цахим сурталчилгааг олон нийтийн сүлжээгээр дамжуулан “<b>Осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх</b>” 1 сарын хугацаатай аян зохион байгууллаа.</p> <p>Иймд Эрүүл мэндийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 04/21 тоот, удирдамж боловсруулан анхан шатны ЭМБ-уудад хүргүүлсэн.</p> <p>Тус аяны хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ахуйн осол, зам тээврийн осол, осголт хөлдөлтөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ослын хор уршгийг таниулах зорилгоор нийт 19 сумын 3 өрхийн 23 удаагийн сургалт зохион байгууллаа.</li> <li>2. Эрүүл мэндийн төвүүд өөрийн цахим сүлжээгээр дамжуулан Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаарх 15 постер, 3 видео, инфографуудыг орон нутгийн олон хандалттай фэйсфүүк г рүлп, пейж хуудсуудаар дамжуулан 10000 гаруй иргэдэд мэдээлэл хүрсэн байна.</li> </ol>	
<p><b>19</b> НЭМ-ийн тэмдэглэлт өдрүүд:</p> <p><b>1. Умайн хүүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагалдлыг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл сургалт сурталчилгаа нэмэгдүүлж цахим сурталчилгааг олон нийтийн сүлжээгээр дамжуулан “Умайн хүүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамрагалдлыг эрчимжүүлэх” 6 сарын хугацаатай аян зохион байгууллаа.</b></p> <p>Иймд Эрүүл мэндийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 20–ны өдрийн А/09 тушаал, удирдамж боловсруулан анхан шатны ЭМБ-уудад хүргүүлсэн.</p> <p>Тус аяны хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Умайн хүүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдах эмэгтэйчүүдэд цахим урилгыг ЭМГ-ын пэйж хуудсаар болон анхан шатны ЭМБ-уудаар дамжуулан зохион байгуулсан.</li> <li>2. Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн төвүүд өөрийн цахим сүлжээгээр дамжуулан Умайн хүүзүүний хорт хавдрын урьдчилан сэргийлэх талаарх 20 постер, 5 видео, инфографуудыг орон нутгийн олон хандалттай фэйсфүүк г рүлп, пейж хуудсуудаар дамжуулан === гаруй иргэдэд мэдээлэл хүрсэн байна.</li> <li>3. Сум, өрхийн ЭМТ-үүд Зорилтод насны эмэгтэйчүүдийг умайн хүүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт орох мэдээлэл сургалт сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх буланг ЭМТөвүүд дээр байгуулсан.</li> <li>2. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдахын ач холбогдлын талаар мэдээлэл сургалт, сурталчилгааг зохион байгуулан иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох</li> </ol>	

зорилгоор “Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлт, хяналтыг сайжруулах” 6 сарын хугацаатай аян зохион байгууллаа.


Иймд Эрүүл мэндийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/09 тушаал, удирдамж боловсруулан анхан шатны ЭМБ-уудад хүргүүлсэн.

Тус аяны хүрээнд:

Сум, өрхийн ЭМТ-ууд Артерийн гипертензийн эмнэлэггүйн удирдамжийн талаар их эмч, бусад үзлэг хийдэг эмч нарын мэдлэгийг дээшлүүлэх, дотооддоо сургалт зохион байгууллаа.

Эрүүл мэндийн газраас боловсруулсан, Эрүүл мэндийн төвүүд өөрийн цахим сүлжээгээр дамжуулан Артерийн гипертензийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаарх 9 постер, 2 видео, инфографуудыг орон нутгийн олон хандалттай фейсфүүк групп, пейж хуудсуудаар дамжуулан === гаруй иргэдэд мэдээлэл хүрсэн байна.

4. ЭМГ-ын пэйж хуудас болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан “СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗӨВЛӨГӨӨ” цуврал 15 төрлийн постерийг нийтэлсэн. Давхардсан тоогоор 000000 иргэн хандаж мэдээлэл авсан байна.



ТАЙЛАН БИЧСЭН:

ХАЛДВАРТ ӨВЧНИЙ АСУУДАЛ

*А. Шаравнямбуу*

А.ШАРАВНЯМБУУ

2025.06.25

ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(АЛБАН ТУШААЛ)

(НЭР, ГАРЫН ҮСЭГ)

(ОГНОО)

ТАЙЛАН ХЯНАСАН:  
НЭМХ-ЫН ДАРГА

*Г.Э.Ариун-эрдэнэ*

Г.Э.АРИУН-ЭРДЭНЭ

2025.07.06

(АЛБАН ТУШААЛ)

(НЭР, ГАРЫН ҮСЭГ)

(ОГНОО)